

# Хүсэл мөрөөдөл тоосрон замхрах нь

*Монгол улсад уурхайн үйл ажиллагаа малчин  
иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг  
тодорхойлон үнэлэх судалгаа*

FORUM-ASIA



## Хураангуйг бэлтгэсэн

ПРАРТНА Рао  
ВАЛЕРИО Лой

## Хянан тохиолдуулсан

Урантүлхүүрийн МАНДХАЙЦЭЦЭН  
Гомбосүрэнгийн УРАНЦООЖ  
МЕЛИССА Анантраж  
ФРИЦЗИЕ Дела Круз Родригуэз

## Судалгааны багийн гишүүд

ПРАРТНА Рао  
ВАЛЕРИО Лой  
Урантүлхүүрийн МАНДХАЙЦЭЦЭН  
Намсрайн БАЯРСАЙХАН  
Готовын ОЮУНТУЯА  
Зураглаач  
Бямбасүрэнгийн БААТАРЗОРИГ

## Орчуулагч

Батбилигийн МӨНХЖИН

## Жолооч

Бямбацэрэнгийн МӨНХТӨР  
Лувсандоржийн МӨНХБАЯР

## Орон нутгийн зохион байгуулагч

Өлзийбаярын ОЮУНЦЭЦЭГ  
Дэмбэрэлийн ГАНТӨР  
Цэеэн-Ойдовын БАТТУЛГА

## Дизайнер

Камикара Ювоно

Copyright © Asian Forum for Human Rights and  
Development (FORUM-ASIA) 2023

The publication is written for the benefit of  
human rights defenders and civil society  
organisations and may be quoted from or  
copied so long as the source and authors are  
acknowledged.



[www.forum-asia.org](http://www.forum-asia.org)



/FORUMASIA



forum\_asia



ForumAsiaVideo



forumasia.humanrights



Sign up to our newsletter [here](#)

## Bangkok Office

S.P.D Building 3rd Floor, 79/2  
Krungthongburi Road, Khlong Ton Sai,  
Khlong San, Bangkok, 10600 Thailand  
Tel: +66 (0)2 1082643-45  
Fax: +66 (0)2 1082646

## Geneva Office

Rue de Varembé 1, 2nd floor,  
1202 Geneva, Switzerland  
Tel: +41 (0)22 740 2947

## Jakarta Office

c/o KontraS  
Jalan Kramat 2 No. 7, Senen  
Jakarta Pusat 10420, Indonesia  
Tel/Fax: +62 (0)21 391 9006

## Kathmandu Office

c/o INSEC  
Syuchatar, Kalanki,  
Kathmandu, Nepal  
Tel: +977 (0)1 521 8770

Email: [info@forum-asia.org](mailto:info@forum-asia.org)

# Гарчиг

<b>Өмнөх үг</b>	<b>5</b>
<b>Судалгааны дүн</b>	<b>7</b>
Судалгаанд хамруулсан эхний сум - Даланжаргалан	7
Хоёр дахь сум - Улаанбадрах	13
Гурав дахь сум - Хатанбулаг	18
Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал	23
<b>Дүгнэлт</b>	<b>29</b>
<b>Зөвлөмж</b>	<b>31</b>





Даланжаргалан суманд амьдардаг малчин өрхийн хашаа хороо

# ӨМНӨХ ҮГ

Монгол улсад олон улсын хүний эрхийн гэрээ болон Үндсэн хуулиар олгогдсон суурь эрхээ эдэлж буйг илтгэх үзүүлэлтүүд өнгөрөгч жилүүдэд үлэмж сайжирсан ч байгалийн баялгийг ашигласны үр дүнд уг үзүүлэлт буурах хандлагатай байна. Засгийн газраас уул уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбараар дахин тодорхойлж, уул уурхайгаас орж ирэх орлогыг нэмэгдүүлж улмаар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээг өсгөх бодлогыг 2020 оноос баримталж эхэлсэн нь хүн амын олон бүлэгт нөлөөллөө үзүүлэхээр байна. Уг нөлөөлөлд автагсдын нэг буюу энэхүү судалгааны гол зорилтот бүлэг бол нүүдэлчин малчин иргэд юм. Хэдэн арван жил мал маллаж, мал сүргээ бэлчээж буй нутгаа малчид өөрсдийн газар гэж бодсоор байгаа хэдий ч уг газрыг ашиглаж, амьжиргаагаа залгуулах эрхээ аажим алдсаар байна. Учир нь засгийн газрын дэмжлэгтэй уул уурхайн компаниуд малчдын малаа бэлчээх газар нутгийг эзлээд зогсохгүй малчдын амьсгалах агаар, ундны ус, эрүүл мэнд болон амьжиргааг доройтуулж байна. Мөн түүнчлэн малчдын эрхээ хамгаалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд заналхийлж, тэдний хүний эрхийг хамгаалагч (ХЭХ)-дад чиглэсэн халдлага энгийн үзэгдэл мэт болжээ.

Тиймээс энэхүү судалгааны гол зорилго нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөх, байгаль орчин доройтох зэрэг шууд болон шууд бус нөлөөнд өртөж буй малчид, ард иргэд, ХЭХ болон бусад талуудын тухай мэдээлэл, нөхцөл байдлыг хуваалцахад оршив. Мөн уг судалгааны ажлын үр дүнд тулгуурлан орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд хийх нөлөөллийн ажилд хэрэглэх тодорхой зөвлөмжийг санал болгох зорилго агуулав.





Даланжаргалан суманд бэлчиж буй мал сүрэг



# Судалгааны дүн

Судалгааны багийн гишүүд Дорноговь аймгийн Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сумдаар айлчилж тэдгээр сумдын ард иргэд, малчид, орон нутгийн захиргааны байгууллага болон засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн төлөөлөл зэрэг өргөн хүрээний оролцогч талуудтай уулзан мэдээлэл цуглууллаа. Тухайн орон нутаг дахь уул уурхайн үйл ажиллагаа ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд хэрхэн халдаж, малчдын амьжиргаа болон хүрээлэн буй орчинд хэрхэн сөрөг нөлөө үзүүлж, зарим тохиолдолд үхлийн хор учруулж буйг энэхүү судалгаагаар баримтжуулсан юм. Бидний цуглуулсан мэдээллээр уул уурхайн нөлөөнд өртсөн ард иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд тавих төрийн хараа, хяналт хангалтгүйн дээр зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар тэмцсэн иргэдийн дуу хоолойг системтэйгээр дарж буй нь илт байлаа.

## Судалгаанд хамруулсан эхний сум - Даланжаргалан

Даланжаргалан сум нь Дорноговь аймгийн хойд хэсэгт байрладаг бөгөөд сумын нийт газар нутгийн 17.341 хувьд нь уул уурхай эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдож, үйл ажиллагаа явагдаж байна. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн улмаас сумын оршин суугчдын эрүүл мэнд, амьжиргаа болон байгаль орчинд маш олон хүндрэл, бэрхшээл тулгараад байна.

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

### Бэлчээрийн газар нутаг хомсодсон

Даланжаргалан сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа нэмэгдсэний улмаас үүссэн хамгийн том өөрчлөлтүүдийн нэг бол бэлчээрийн газар хомсодсон явдал байлаа. Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа эхлээгүй байх үед малын бэлчээр хангалттай байсан бол одоо бэлчээрийн газар маш цөөрч, хоорондын зай их холджээ.



## Даланжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг уурхайн ойр амьдарч буй малчин айл



Мөн түүнчлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг тендер зарлан сонгон шалгаруулах тухай холбогдох хуулинд өөрчлөлт орсноос хойш тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг олгох үйл явц улам хялбар болж ингэснээр бэлчээрийн газар нутаг багасахад улам нөлөөлсөн байна. Тухайлбал, уг сумын нутагт тендерийн сонгон шалгаруулалтаар олгогдсон ашигт малтмалын 10 тусгай зөвшөөрлийн координатыг шалган үзэхэд 100 малчин өрхийн бэлчээрийн газар болон 70 ундны усны худаг өртсөн тухай сумын төрийн байгууллагынхан судалгааны багийнханд мэдээлсэн юм. Энэхүү механизмаар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг үргэлжлүүлэн олгох аваас малчид малаа бэлчээх газар улам хомсдохын зэрэгцээ орон нутгаасаа алс хол нүүн дайжих улмаар мал маллан амьдрах амьжиргааны арга хэлбэрээ солихоос өөр гарцгүй болох эрсдэлтэй байна.

Бэлчээрийн газар нутаг хомсодсон бас нэг шалтгаан бол ашигт малтмалын тусгай

зөвшөөрлийг тусгай хамгаалалттай газар нутагт олгож буй явдал юм. Хуулиар хамгаалуулах ёстой тусгай хамгаалалттай газар нутагт хүртэл ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдож байгаа нь уул уурхайд өртөхгүй газар нутаг үлдэх эсэхэд малчдыг эргэлзэхэд хүргэж байна. Мөн уул уурхайн компаниуд хайгуул хийсэн, олборлолт, ашиглалт явуулсан газар нутгийг нөхөн сэргээхгүй, хордуулан, цаашид олон жилийн хугацаанд ашиглах боломжгүй болгон үлдээж байна.

### Өрхийн орлого, амьжилгааны түвшинд нөлөөлсөн

Судалгааны баг (СБ)-ийн малчидтай хийсэн ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлгийн үеэр олж илрүүлсэн бас нэгэн чухал сэдэв бол уул уурхайн үйл ажиллагаа нь малчдын өрхийн орлого, амьжиргаанд сөргөөр нөлөөлж, эдийн засгийг доройтуулж буй тухай байлаа. Малчдын





амь зуух, амьжиргаагаа залгуулах гол зүйл бол мал сүргийн ашиг шим хийгээд малын гаралтай түүхий эдийн зах зээлийн үнэ юм. Харамсалтай нь уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд үүсч буй хүнд машин механизм зорчин өнгөрөх үеийн замын тоос шороо, хатаж ширгэсэн худаг, булаг, мал бэлчээхэд үржил шимгүй орхигдсон газар зэргээс мал сүргийн ашиг шим үлэмж хэмжээгээр доройтож буйг олон малчид хэлж байлаа. Үүний нэг жишээ нь малын ноос, ноолуурын чанар муудахын хэрээр ноос, ноолуураа зарж, борлуулах үнэ буурч байна. Ийнхүү малын гаралтай бүтээгдэхүүний чанар доройтон арилжааны шаардлага хангахгүй, орлого буурснаас малчин өрх хүнсний хэрэгцээгээ хангаж чадахгүйд хүрч байна. Өрхийн амьжиргаа залгуулах орлого буурахын сацуу уул уурхайн тусгай зөвшөөрөл олгосон газар нутагт мал бэлчээх боломжгүй тул сумын төвөөс улам холдон дайжиж, ингэснээр тээврийн зардал нэмэгдэж, хуримтлалгүй болоход хүргэж байна.

Суманд мал маллахаас өөрөөр аж төрөх, орлого олох боломж хомс тул ийнхүү өрхийн орлого буурч буй нь малчин иргэдийг туйлын хүнд байдалд оруулж байгаа юм. Иргэд газар тариалан эрхлэх, мал маллах болон уул уурхайн компанид ажиллах зэргээс өөрөөр орлого олох боломжгүй байдаг тухай сумын орон нутгийн удирдлагуудтай хийсэн хэлэлцүүлгээр хэлж байлаа. Харин уул уурхайн компаниуд мэргэжлийн ажиллах хүчийг Улаанбаатар хотоос бүрдүүлдэг тул зөвхөн мэргэжил, чадвар бараг шаардахгүй, бага цалинтай ажлын байрууд л орон нутгийн иргэдэд оногддог байна.

Уул уурхайн салбарт ажиллаж буй эмэгтэй ажилчид бүтэн цагийн ажлынхаа хажуугаар гэр орныхоо ажлыг амжуулах давхар ачаалалтай нүүр тулдаг байна. Энэхүү ачаалал нь Ковид-19 цар тахлын тархалтын үед мөрдөж байсан халдвар хамгааллын дэглэмийн үед гэртээ харих зэрэгт улам хүндрэлтэй байжээ.

## Малчдын эрүүл мэнд доройтсон

Уул уурхайн үйл ажиллагаанаас болж иргэдийн биеийн эрүүл мэнд доройтож, сэтгэл санааны хохиролд орж байна. Хамгийн түгээмэл тохиолдож буй зовуурь бол иргэдийн уушиг өрөвсөж, амьсгалын замын өвчлөлд ихээр өртөх болжээ. Зарим иргэд удаан хугацаанд тоос, шороо, химийн бодис дэгдсэн агаараар амьсгалснаас болж дархлаа муудаж, өөр олон төрлийн өвчлөлд нэрвэгддэг болсон тухайгаа ярьж байлаа.

Орон нутагт үйл ажиллагаа явуулдагуул уурхайн компаниуд эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулдаггүйн улмаас иргэд өөрсдөө эрүүл мэндийн үзлэгт тухай бүрт нь хамрагдах боломж байдаггүй. Иймээс иргэдэд тулгараад буй эрүүл мэндийн асуудлууд нь уул уурхайн компаниудын үйл ажиллагааны улмаас үүссэн гэдгийг нотлох боломжгүйд хүрч, тэдгээр компаниуд ч холбогдох хариуцлага хүлээдэггүй байна.

Ихэнх хүмүүс ямар нэгэн өвчний шинж тэмдэг илэрсэн үед л эмнэлгийн байгууллагад хандаж, эм тарианы үнийг өөрсдөө төлөхөөс өөр аргагүйд хүрдэг гэжээ. Сумын орон нутгийн удирдлагуудтай хийсэн ярилцлагын үеэр 2021 онд нэг багийн 30 иргэнд хийсэн эрүүл мэндийн үзлэгээр 17 иргэний биед хүнд металл илэрсэн ч ямар нэгэн арга хэмжээ аваагүй хэвээр байгаа тухай дурьдсан. Ярилцлага өгсөн зарим иргэдийн хэлж буйгаар орчны бохирдлын улмаас харшил, арьсны тууралт элбэг тохиолдож, хоолой хорсох, ханиалгах зэргээр бага насны хүүхдийн эрүүл мэнд ч өртөөд байгааг хэлсэн юм.

Бие мах бодын эрүүл мэндээр хохирохоос гадна сэтгэл санааны хямралд өртдөг тухайгаа ярилцлага өгсөн эмэгтэйчүүд ярьж байлаа. Сэтгэл санааны хохирол гэдэгт малын бэлчээр хайж олон жил нутагласан газраасаа дайжихад хүрч, мөн цаашид гэр бүл нь хэрхэн амь зуух тухайд тогтмол санаа зовсноос болж гүн хямралд ордог тухайгаа ярьсан юм. Ялангуяа сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай ямар нэгэн хуулинд заагаагүй тул цаашид мал маллахаа болих тухай ч эргэцүүлж буйгаа хэлж байлаа.

## Малын эрүүл мэнд доройтсон

Орон нутгийн иргэд болон малчдын хамгийн их гомдол мэдүүлж буй асуудал бол уул уурхайн үйл ажиллагаа малын эрүүл мэндийг доройтуулж буй явдал байлаа. Мал эрүүл биш байх нь тэдний оршин тогтнох болон өрхийн орлого, амь зуулгад заналхийлж байна гэсэн үг. Бүлгийн хэлэлцүүлгийн үер малчид малынх нь арьс, нүд, уушиг, элэг гэх мэт эд эрхтнүүд нь өөрчлөлтөд орж байгааг хэлж байсан юм. Сүрэгт сүргийн алхааг гүйцэхгүй, удаан алхаатай заавал нэг мал үзэгдэх болсон ба малын уушиг идээлж, ногоон цэнхэр өнгийн өтгөн зүйл гардаг гэж нэгэн малчин хэлж байлаа. Өөр нэгэн малчин хоёр

толгойтой төл төллөсөн тохиолдол гарсныг мөн хуваалцав.

Орчны бохирдлын улмаас малын эд эрхтэн хордоод зогсохгүй уул уурхайн үйл ажиллагааны улмаас бэлчээрийн газар хомсодсон, мал услах ус хатаж ширгэсэн нь мал сүргийг улам бүр доройтуулах гол шалтгаан болж байв. Мал сүргийн эрүүл мэндийн доройтол төлийн эндэгдэлд хүргэж, малчдын хүнс, орлогод мөн дам нөлөө үзүүлж байгаа аж. Цаашлаад зохих ёсны дагуу булж, амсрыг нь хаагаагүй уурхайн цооногуудад мал унаж, эндэх эрсдэлийг улам нэмэгдүүлдэг байна.

## Газар нутгаасаа дайжин нүүснээс үүсэх ур дагавар

Mining in the area threatens to change the way the Тус сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаанаас болж олон арван жил нүүдэллэн, мал аж ахуйгаа эрхлэн амьдарч ирсэн малчид амьдрах аргагүйд хүрч, бэлчээр хайн өөр нутаг руу нүүх эсвэл Улаанбаатар хот руу бүр мөсөн суурьшихаар дайжиж буй талаар малчид ярилцлагын үеэр онцолж байлаа.



Даланжаргалан сумын ширгэх дөхсөн худаг



Бэлчээрийн газар хайн нутаг сэлгэн нүүх нь малчин өрхийн хүүхдийн боловсролд шууд нөлөөлдөг байна. Орон нутгийн удирдлагуудтай хийсэн хэлэлцүүлгийн үеэр нийт бага насны хүүхдийн 75 хувь нь сургуулийн өмнөх насны боловсрол эзэмшиж чаддаг бол үлдсэн 25 хувь нь эцэг нь бэлчээр хайн нүүснээс болж уг боловсролыг эзэмшиж чадалгүй завсарддаг гэжээ. Ийнхүү сургуулийн боловсролоос завсардах нь тэдгээр хүүхдүүдийн ирээдүйн амьдралд тохиох олон боломжуудаас хоцрох эхлэл тавигдаж, улмаар ядуурлаас гарахад улам хүндрэлтэй болох юм. Бэлчээрийн газар хомсодсоноос болж өөр нутагт газар хайсан малчид заримдаа газар булаалдан таргах, ах дүүс хүртэл хоорондоо эв түнжин хагарах тохиолдол гардаг гэлээ.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХ

### Усны нөөцийн хомсдол

АБэлчээрийн газар хомсодсоноос үүдэн мал бэлчээх боломжтой газарт нутагт бэлчээрийн даац хэтэрч, улмаар гадаргын ус хомсдож, ширгэхэд нөлөөлж байна. Мал услах уснаас гадна малчдын ундны ус хүртэл хомсдоод байгааг ярилцлагын үеэр онцолж, өдөрт 10-30



км зам туулан мал ундаалах усанд хүрдэг гэжээ. Амьжиргаа залгуулах өрхийн орлого багасч, малын эрүүл мэнд доройтсон үед ийнхүү хол газар байнга явж малаа услах нь амь зуухад улам хүнд болгож байна

Хөрсний болон гүний усыг уул уурхайн хамааралтай үйл ажиллагаа эрхлэгчид давуу эрхтэйгээр ашиглаж байгаа нь малчдын амьдралыг улам доройтуулж байна. Үүний нэг жишээ дурдахад, малчид ойр хавийн гол горхи хатаж, худаг ширгэж буй талаар уул уурхайн компанид гомдол гаргахад тэд ойр орчимд нь шинэ худаг гаргаж өгдөг ч тэдгээр худаг нь цахилгаанаар эсвэл дизель генератороор л ажиллах ба худгаас ус авахад малчид мөнгө төлөх шаардлагатай болдог байна. Тэгэхээр уг компани нутгийн иргэдэд туслах, асуудлыг нь шийдэх бус харин эсрэгээр худгийн усыг зарж ашиг олон, малчдын амьдралд улам нэрмээс болж, санхүүгийн хямралд унагаж байна.

### Тоос, шороо босож, орчны чимээ нэмэгдсэн

Уул уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш нутгийн иргэд дан ганц уурхайн үйл ажиллагааны чимээнд бус мөн түүнчлэн уурхайгаас нүүрс тээвэрлэж буй том оврын ачааны машины босгосон тоосонд нэрвэгдэж байгаа гэжээ. Орчинд маш их хэмжээний тоос үүсч байгаагийн гол шалтгаан нь тэдгээр тээврийн ачааны машин шороон замаар зорчсоноос болдог байна. Тоосыг багасгахын тулд компаниуд зам услах зэрэг арга хэмжээ авдаг ч энэ нь тухайн орон нутагт байнга амьдарч буй иргэдэд урт хугацаанд нь үр дүн өгөхгүй байна. Ярилцлага өгсөн нэг иргэн шөнийн цагаар үүсэх тоос болон орчны чимээнээс болж шөнө амар тайван унтаж чадахаа больсон гэсэн юм.

Уурхайн орчмоос ялангуяа салхитай үед ихээр ялгарч, амьсгалах аргагүй болгодог таагүй үнэрийн талаар цөөн хэдэн иргэд гомдоллож байлаа. Уг таагүй үнэр нь ихэвчлэн уурхайн баяжуулах явцад ашиглагддаг хүхрийн үнэр бөгөөд агаарт цэнхэр утаа болон суунагладаг гэжээ. Нутгийн удирдлагыг төлөөлж байсан албаны хэдэн хүмүүсийн ярьж буйгаар уг компаниуд хоцрогдсон технологи ашиглаж байгаа нь орчны бохирдлыг улам нэмэгдүүлэхэд хүргэж байгаа юм байна.

## ИРГЭНИЙ БА УЛС ТӨРИЙН ЭРХ

### Мэдээллийн ялгаа болон харилцааны дутагдал

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон уурхайн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг холбогдох байгууллагууд тухайн орон нутгийн удирдлагуудад ил тод, цаг тухайд





### Улаанбадрах суманд үйл ажиллагаа явуулдаг “Бадрах Энержи” ХХК-ийн уурхайн кемпүү нэвтрэх хаалга

нь мэдэгддэггүй талаар нутгийн удирдлагууд хэлэлцүүлгийн үеэр хэлж байлаа. Орон нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдож буй, шинээр хууль батлагдсан эсвэл холбогдох хуулинд өөрчлөлт орсон тухай гэх мэт нутгийн иргэдэд шууд нөлөөлөх шийдвэрүүдийг ч иргэдтэй хэлэлцэлгүй гаргадаг гэжээ. Зарим тохиолдолд иргэд уурхайн үйл ажиллагаа эхлэх үед л энэ тухай мэддэг тухайгаа хуваалцсан юм

Иргэдтэй хийсэн ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгийн үеэр нутгийн иргэдуулуурхайтай холбоотой шийдвэрүүдийн талаар мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явцад шууд оролцох хүсэл сонирхол маш их байдаг нь илэрхий байлаа. Ялангуяа иргэд уул уурхайн нөлөөнд өртсөн газарт амьдарч буйн хувьд судалгаанд хамрагдах, үнэлгээний явцад оролцох хүсэлтэй байдаг тухайгаа илэрхийлж байсан юм. Уул уурхайн зарим компаниуд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ) батлуулах хугацаа дөхсөн үед иргэдээс зөвшөөрөл авах гэж оролддог тухай иргэд судалгааны багийнханд мэдээлсэн. Хуулинд БОНУ-г орон нутгийн иргэдийн хурлаар “хэлэлцүүлэх” тухай заасан байдаг ч түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай тодорхой тайлбарыг уг хуулинд оруулаагүй ажээ. Ер нь систем нь бүхэлдээ урвуугаараа ажилладаг буюу орон нутгийн иргэдийн хурлаар хэлэлцүүлэхээс өмнө ашигт малтмалын

тусгай зөвшөөрлийг аль хэдийн олгочихсон байдаг тухай олон хүн шүүмжилж байлаа. Багийн болон сумын иргэдийн хурлаар хэлэлцсэн асуудлын хэрэгжилтийг хэлэлцэхгүйгээр нэгл асуудлаа ахин дахин яриад байдаг иргэд бухимдалтай байдаг тухайгаа хэлж байлаа. Зарим тохиолдолд нэг л асуудлын талаар хэдэн сар дамнан хурлаар хэлэлцдэг ч хэрэгжүүлэх алхам хийгддэггүй байна. Үүнээс иргэдийн итгэл цөхөрдөж, найдвар мухардана. Зарим тохиолдолд сумын удирдлага асуудлыг шийддэг ч ихэнхдээ түр зуурын гал унтраасан шийдвэр байдаг. Үүний учир нь тэдгээр асуудал нь багийн болон сумын засаг даргийн эрх мэдлийн хэмжээнээс давсан байдаг орших ажээ. Мөн ихэнх асуудлууд өршөөлийн хуулинд хамрагдах, эсвэл хэн нэгний хувийн ашиг сонирхлын улмаас шийдэгдэхгүй өнгөрдөг тул өөрчлөлт авчрах жаахан ч чадавхгүй байна.

### Заналхийлэх, дарамт, шахалт үзүүлэх

Зарим тохиолдолд иргэд болон төрийн байгууллагын өмнө тулгамдсан, нэн тэргүүнд шийдвэрлэхээр сонгосон асуудлуудын хооронд алд дэлмийн зөрүү байх ба иргэд төрийн байгууллагад уул уурхайн эсрэг гомдол гаргахад хариуд нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр айлган сүрдүүлдэг байна. Уул



уурхайн компаниудаас ч удаа дараа дарамт, шахалт ирж байсан тохиолдлуудыг дурьдаж байсан юм. Уурхайн компани орон нутгийн иргэдээс хүний нөөцийн бүрдүүлэлт хийхдээ тэдний шаардлагыг биелүүлэх, үл эсэргүүцэх гэсэн нөхцөл тулгадаг байна. Мөн уурхайн ойр орчим амьдарч байсан 3-4 айлыг хүчээр нүүлгэн шилжүүлсэн тухай өөр нэгэн иргэн ярилцлагын үеэр мэдээлж байлаа. Эдийн засгийн баялаг бүтээх нэрийдлээр ийнхүү малчдын амьдрал сүйдэж буй нь илүү нухацтай асуудлыг дагуулж байна.

## Хоёр дахь сум - Улаанбадрах

Улаанбадрах сум нь Дорноговь аймгийн зүүн хэсэгт оршдог бөгөөд нийт сумын нутаг дэвсгэрийн 8 хувьд нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон. Уг сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг уурхайн зарим нь уран олборлодог бөгөөд энэ нь эргэн тойронд нь амьдардаг иргэд радио идэвхт бодисын сөрөг нөлөөнд автахад хүргэж байна. Улаанбадрах сум нь БНХАУ-ын хилээс урагш 60 км-т оршдог ба ашигт малтмал экспортод гаргах байршлаараа стратерийн ач холбогдолтой суманд тооцогддог. Манай судалгааны баг уг сумын нутагт ашигт малтмалын 3 тусгай

зөвшөөрөл эзэмшдэг Бадрах Энэржи ХХК-ийн үйл ажиллагаа нь хүрээлэн буй байгаль орчин болон иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буйд түлхүү анхаарлаа хандуулсан. Бадрах Энэржи ХХК-ийн 66%-ийг Франц улсын хөрөнгө оруулалттай Арева Монгол ХХК эзэмшдэг бол 34%-ийг нь Монгол улсын засгийн газар Мон Атом ХХК-аар дамжуулан эзэмшдэг ажээ.

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

### Уул уурхайг дэмжих

Экспортын түнш БНХАУ-тай хиллэдэг тул газарзүйн байршлаараа Улаанбадрах сум нь улсын ДНБ-ний саалийн үнээ л гэсэн үг. Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдах хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын тоо болон тэдгээрийн төлдөг ашигт малтмалын нөөц ашигласан татвартай шууд хамааралтай байдаг тухай сумын засаг дарга ярилцлагынхаа үеэр онцолсон юм. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас сөрөг үр дагаврыг амсаж байгаа ч уул уурхайн компаниудын хувь нэмрээс зам барих, гудамжны гэрэлтүүлэг хийх, шинээр худаг гаргах болон малын өвс тэжээл авах зэрэг иргэдэд чиглэгдсэн хөгжлийн төсөл



хөтөлбөрүүд шууд хамааралтай байгаа нь сумыг ацан шалаанд оруулж байна.

Уул уурхай нь хамгийн өндөр цалин, хөлс өгдөг салбар учраас орон нутгийн иргэдийн уул уурхайгаас хамаарах нөхцөл байдлыг улам хүндрэлтэй болгож байна. Амьжиргаагаа залгуулахын тулд уурхайн компанид ажилд орсон иргэд уурхайн компанийн эсрэг арга хэмжээ авахад саад болж байна. Орон нутгийн зарим иргэдийг ажилд авснаар компани нь орон нутгийн иргэдийг хооронд нь талцуулж байна гэж иргэд хардаж байна.

## Буруутгах, няцаах эцэс төгсгөлгүй үйлдэл

Нутгийн малчин иргэдэд шударга ёс тогтооход тулгарч буй хамгийн хүндрэлтэй бэрхшээлүүдийн нэг нь нотлох баримт цуглуулах явдал. Учир нь малчид, иргэд амьдрал, амьжиргаанд нь уул уурхайн үйл ажиллагаа шууд нөлөөлж буйг баталж, нотолж чадахгүй байгаадаа сэтгэл дундуур байгаагаа бараг бүх ярилцлага, хэлэлцүүлгийн үеэр илэрхийлж байлаа. Ийнхүү батлах, нотлох баримтгүй тул уурхайн компаниудад тэдний үйл ажиллагааны үр дагаварт ямар нэгэн хуулийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байгаа юм. Ихэнх тохиолдолд шинжилгээ хийлгэсэн лабораторын дүгнэлтийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрөх эсэхээс шалтаглан тухайн уурхайн компанийн эсрэг нотлох баримтаар тооцохгүй гэсэн дүгнэлт гардаг гэжээ. Ийнхүү шинжилгээний дүгнэлтийг нотлох баримтын

шаардлага хангахгүй гэсэн шалтгаанаар уул уурхайн компанийн эсрэг иргэд цаашид зарга үүсгэх боломжгүй болгох арга байнга үйлчилдэг байна.

Судалгааны багийнхан Сайншанд суман дахь аймгийн Малэмнэлгийн газрын удирдлагуудтай уулзан уул уурхайн үйл ажиллагаанаас малын өвчин, хорогдол гардаг эсэхийг асуухад баталгаатай тохиолдол бүртгэгдээгүй гэж хариулсан ба малын эрүүл мэндийн доройтол, тоо толгойн хорогдлыг малчдын хайнга байдал, 1000 толгой мал тутамд 1-2 малчин ногдож байгаатай холбон тайлбарлаж байлаа.

## Малын өвчлөлөөс үүссэн санхүүгийн алдагдал

Даланжаргалан сумын малчидтай адил малын эрүүл мэнд доройтсоноос болж малчдын орлого буурсаар байна Улаанбадрах сумын малчид ярьсан. “Хоёр толгойтой, гурван хөлтэй, нэг нүдтэй төл”, хээл хаях, малын уушиг, элэг, зүрх нь өвчилсөн гэх мэт яриа үүнд хамаарна. Ярилцлага өгсөн нэг малчин найман хөлтэй ишиг, ямар ч үсгүй тугал төрснийг нүдээрээ харсан ба малын амнаас цагаан хөөс сагах, туулгах асуудал байнга тохиолддог болсон гэсэн. Харин зарим малчид мал хордсоноос болж 2021 оны хаврын бүх төлөө алдсан хэмээн дуу нэгтэйгээр гэрчилж байлаа.

Малчид малаа төхөөрөхөд малын элэг, уушиг идээлж, бүтцийн өөрчлөлтөд орсон байдаг



Улаанбадрах сумын хүүхэд, залуус



тул малын дотор гэдсийг хаяж, харьцангуй гайгүй хэсгийг нь өөрсдөө идэх эсвэл бусдад зардаг гэж байлаа. Улаанбадрах сумын махыг хүмүүс авахаа байсан болохоор малчид малаа өөр сумынх гэж гарал үүслийг нь нуун зардаг болсон гэж хэдэн малчин үнэнээ өчиж байсан юм.

Малын дотор гэдэс ийнхүү өвчилсөн талаар сумын малчид “Бадрах Энержи”ХХК-д удаа дараа хандаж, өвчилсөн малын дотор гэдэс болон эндсэн малаа хүртэл авчран харуулж байжээ. Гэсэн хэдий ч компанийн байнга өгдөг хариулт бол өөрсдийнх нь үйл ажиллагаанаас ийм үр дагаварт хүрсэн хэмээн итгэдэггүй тул нотлохыг л шаарддаг аж. Харамсалтай нь малчид иймэрхүү тохиолдолд хуулийн ямар заалтыг хэрхэн мөрдөх талаар мэдлэг хомс, хуулийн гомдол гаргаж, хөөцөлдөх, хөндлөнгийн лабораториудад дээж шинжлүүлэх санхүүгийн боломж хязгаарлагдмал байдаг нь мухардалд хүргэдэг байна. Судалгааны багийнхан уг асуудлыг компанийн төлөөлөгчдөөс асуухад мөн л баримт, нотолгоо шаардаж байлаа. Компанийн төлөөлөгчийн хэлснээр Орон нутгийн хөгжлийг дэмжих алба компанид байдаг бөгөөд уг алба малчдын дуудлагаар газар дээр нь очиж, зураг авч, баримтжуулах зорилготой боловч малчдаас нэг ч удаа ийм хүсэлт ирж байгаагүй гэжээ. Хариуд нь малчид Орон нутгийн хөгжлийг дэмжих гэх алба огт байдаггүй ба хийсэн бүтээсэн зүйлээс нь өдий болтол нэгийг ч хараагүй гэсэн байна.



Улаанбадрах сумын малын махыг хордоогүй, эрүүл, хүнсэнд хэрэглэхэд асуудалгүй гэдгийг батлах зорилгоор Бадрах Энержи компанийнхан сумын иргэдээс мал худалдан авч, уурхайн ажилчдын хүнсэнд хэрэглэдэг. Гэхдээ тэд махыг нь худалдаж авахын оронд малыг нь амьдаар нь худалдан авч, Улаанбаатар хотруу тээвэрлэн, нядалгаанд оруулж, мал эмнэлгийн шинжилгээ хийлгэсний дараа уг махыг эргүүлэн уурхайн кемпрүү авчирдаг байна. Гэвч нутгийн иргэд хотоос ирж буй махыг үнэхээр Улаанбадрах сумын малын мах эсэхэд эргэлздэг бөгөөд харин компанийг тухайн орон нутгийн малын махыг хордоогүй гэдгийг батлах нэг тактик байх магадлалтай гэж харддаг талаараа хуваалцсан юм.

## Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал

Эрүүл мэнд доройтсон тохиолдлуудаас хамгийн ноцтой нь жирэмсэн эмэгтэйчүүдэд тулгарч буй нь байлаа. Ярилцлага өгсөн хэд хэдэн малчин нэг нутаг усанд амьдардаг бие давхар дөрвөн эмэгтэйн ураг зулбасан тохиолдол гарсан тухай ам уралдан ярьцгааж байсан юм. Гэвч аймгийн удирдлагууд 4 эмэгтэйн ураг дараалан зулбасан уг харамсалтай тохиолдлын шалтгааныг тодруулахыг хичээхийн оронд нэгэн телевизээс энэхүү явдлыг сурвалжлах баг ирэхэд уг хэргийг нуун дарагдуулсан байжээ.

Дээрх дөрвөн эмэгтэйн нэгнийх нь нөхөр судалгааны багийнханд өгсөн ярилцлагадаа тэднийг эмнэлэгт хандахад “ургийг хангалттай сайн харж, хандаагүй байна” хэмээн эхнэрийг нь буруутгасан дүгнэлт гаргасан гэжээ.

Өөр нэгэн эмэгтэй 5 сартай ихэр ургаа алдсан ба зулбах үед савны ус нь ногоорсон байсан тул ургийг Улаанбаатар хотын лабораторид шинжлүүлэхээр явуулсан ба шинжилгээний хариу нь уг эхнэр нөхөр хоёрыг цус ойртсоноос болж ураг зулбасан хэмээн дүгнэлт гарсан байна. Гэвч уг гэр бүл цус ойртоогүй байсан гэжээ.

Бас нэгэн эмэгтэйн бага хүү сэтэрхий уруултай төрсөн бөгөөд тэд шалтгааныг нь уранд хордсон гэж үздэг ажээ. Учир нь тэр эмэгтэйн том хоёр хүүхэд өөр аймагт төрсөн бөгөөд эрүү нүүрний ямар нэгэн гажиггүй, эрүүл хүүхдүүд төрсөн байна. Тэрээр сумын удирдлагууд болон Бадрах Энержи компанид энэ тухайгаа хэлсэн ч нааштай, тодорхой хариулт одоог хүртэл аваагүй гэжээ.

**Улаанбадрах сумын малчин, савласан ус (зүүн) болон малчдын худгаас авдаг ундны усны (баруун) ялгааг харуулж байна.**



## **БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХ**

### **Ус, агаар, газрыг бохирдуулсан**

Ярилцлага, хэлэлцүүлэгт оролцсон хүн бүр толгой дараалан ундны ус бохирдож байгаад хамгийн их гомдол мэдүүлж байлаа. Ураны уурхайн үйл ажиллагааны улмаас газрын гадаргын болон гүний ус бохирдсон нь малчид ундны болон мал услах усгүй болоход хүргэжээ. Шар нунтаг олборлох явцад гүний ус хордох боломжгүй хэмээн Бадрах Энержи компанийнхан хэлж байгаа ч бодит байдал эсрэгээрээ байлаа. Ярилцлага өгсөн нэг малчин хэлэхдээ тэдний нутагладаг газрын ойр байдаг худгаас авсан усыг 2 хоногт хэрэглэхгүй л бол усанд үнэр ордог тухай ярьсан юм. Монгол улсын Ерөнхий сайдын ажлын хэсгээс мэргэжлийн хүмүүс уг сумын нутагт ирж, хөрсний уснаас шинжилгээ авсан ба дүгнэлт нь уг усан дахь хүнд металлын найрлага зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даруй 3 дахин их байсан бөгөөд хүн, малын эрүүл мэндэд хортой, үхэлд хүргэх аюултай гэсэн байна. Гэвч уг дүгнэлттэй холбоотойгоор асуудлыг шийдвэрлэх, ямар нэгэн арга хэмжээ одоог хүртэл аваагүй байна.

Байгаль орчныг доройтуулж буй бас нэгэн асуудал бол цөлжилт байлаа. Уур амьсгалын дулаарал цөлжилт үүсэх шалтгааны 40 хувийг бүрдүүлж байж болох ч үлдсэн 60 хувийг уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс үүссэн гэж ярилцлагад оролцогчид үзэж байна. Мөн олон төрлийн өвс, ургамал ховордож, оронд нь мал иддэггүй өөр төрөл зүйлийн ургамал ургаж эхэлсэн байна. Гэвч Бадрах Энержи компанийнхан хучмал зам тавих, замаар зорчиж буй ачааны машины хурдны хязгаарыг баримтлах, ойр хавийн ус, хөрснөөс тогтмол дээж авч – шинжлүүлэх, аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлж, хууль журмын дагуу зохистой зайлуулах, орчныг зүлэгжүүлэх болон малд өвс тэжээл өгөх зэргээр уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг хамгийн бага байлгахад чиглэгдсэн олон арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлдэг тухайгаа судалгааны багийнханд хэлж байлаа.



## ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХ

### Бадрах Энержи компанийн хууран мэхлэлт ба дарангуйлал

Хуулинд БОНУ-г батлуулахаас өмнө орон нутгийн иргэдийн хурлаар хэлэлцүүлнэ гэж заасан байдаг. Гэвч Бадрах Энержи компанийнхан сумын иргэдэд мэдэгдэлгүйгээр БОНУ-гээ зальдан батлуулсан хэмээн ярьсан юм. Компанийн төлөөлөгчид багийн хурал дээр ирээд хуралд оролцож байсан малчдад “сайн малчин” цол олгож, жижиг бэлэг дурсгалын зүйл тараасан ба БОНУ-ний талаар асуудал хөндөгдөх үед багийн хуралд сууж байсан иргэдийг хурлын ирц бүртгүүлэх хуудсанд нэрээ бичихийг хүссэн гэжээ. Дараа нь хэдийгээр уг БОНУ орон нутгийн иргэдийн хурлаар хэлэлцүүлэгдээгүй ч холбогдох яам нь баталсан байсан тухай иргэд олж мэджээ. Өөр нэгэн иргэн мөн Бадрах Энержи компанийг хуулинд заасан олборлолт гэдэг угийг гуйвуулж “туршилтын олборлолт” хэмээх шинэ нэр томъёог гаргаж ирж, хуулийн заалтыг гуйвуулан ашиглаж байна гэсэн юм. Уг иргэний үзэж буйгаар “туршилтын орлборлолт” гэдгийг зохицуулах хуулийн заалт одоогоор байхгүй байгаа гэжээ. Зарим иргэд уг компанийг эцсийн бүтээгдэхүүн болох шар нунтгаа хууль бусаар борлуулж, хаягдлыг нь зохисгүйгээр булж байгаа хэмээн харддаг тухайгаа илэрхийлж байлаа.

Мөн Бадрах Энержи компанийнхан иргэдийг дарамталдаг гэж иргэд өөрсдөө гэрчилж байсан ч компанийн төлөөлөгчид “ямар нэгэн дарамт, шахалт хэзээ ч үзүүлж байгаагүй” гэсэн хариу өгсөн.

### Ил тод байдал, дэмжлэг байхгүй

Сумын удирдлагын зүгээс ямар нэгэн дэмжлэг байхгүй, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой өрнөж буй хэлэлцүүлэгт иргэдийг оролцуулдаггүй, мэдээллээр хангадаггүй хэмээн сумын иргэд удаа дараа гомдоллож байлаа. Гэтэл Бадрах Энержи компанийн төлөөлөгчид өөрсдийгөө сумын иргэдтэй “нээлттэй харилцдаг, компанийн үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны талаарх мэдээллээр хангадаг” гэсэн хэвээр байсан юм.

Ерөнхийсайдынажлыналбанаасболовсруулсан тайланг зөвхөн аймгийн удирдлагуудтай хэлэлцэн, уг тайлангийн дүгнэлттэй холбоотой ямар нэгэн арга хэмжээ огт авагдаагүй талаар судалгааны багийнханд иргэд хэлж байсан. Иргэд уг тайлантай танилцах хүсэлт гаргахад тайланд агуулагдаж буй мэдээлэл нууцад хамаарна хэмээн татгалзсан хариу авсан байна. Мөн аймгийн удирдлагууд иргэдийг дараагийн арга хэмжээ авахыг нь хааж боогдуулах замаар иргэдийн эсрэг байр суурьтай байсан нь илэрхий байсан ба иргэдийн дуу хоолойг хүртэл дарахыг оролдож байсан гэжээ. Бадрах Энержи компанийн тухай Facebook пост оруулсан иргэнийг “сумын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх” тул арилгахыг шаардсан тохиолдол гарчээ. Энэ



Хатанбулаг суманд ашигт малтмал тээвэрлэж буй том оврын тээврийн ачааны машинууд





### Хатанбулаг суманд бэлчиж буй мал сүрэг

мэт шахалт, хавчлага үүгээр зогсохгүй ба иргэд компанийн уурхайн гадаа очиж эсэргүүцлээ илэрхийлэхэд орон нутгийн цагдаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бус харин оронд нь компанийн эд хөрөнгийг эвдэж сүйрэхээс хамгаалж байсныг олон хүн гэрчилж байлаа.

Эцэст нь мэдээллийн ил тод бус байдал зөвхөн нутгийн иргэдэд тохиолддог бэрхшээл биш ажээ. Тухайлбал, Бадрах Энержи ХХК Улаанбадрах сумтай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан ч уг гэрээний нэг хувь сумын засаг даргад хүргэгдээгүйгээс гадна БОНУ-ний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл ч ирээгүй байгаа талаар засаг дарга сурвалжлах багийнханд хэлсэн юм.

## Гурав дахь сум - Хатанбулаг

Хатанбулаг сум Дорноговь аймгийн өмнөд нутагт оршдог бөгөөд газар нутгийнхаа хэмжээгээр хамгийн том суманд тооцогддог. 2022 оны 12 дугаар сарын байдлаар сумын нийт газар нутгийн 11.8 хувьд уул уурхайн тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Улаанбадрахын адилаар Хатанбулаг сум БНХАУ-ын хилтэй ойр байрлах тул эдийн засгийн өндөр ач

холбогдолтой. Байнгын ажиллагаатай хилийн боомт үйл ажиллагаа явуулж, экспортод гаргах нүүрсийг саадгүй хилээр нэвтрүүлдэг ч үр дүнд нь сумын иргэд, мал амьтан, байгаль орчин үлэмж хэмжээгээр нэрвэгдэж байна.

## ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

### Эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэгдүүлэх дарамт, шахалт

Сумын иргэдтэй хийсэн ярилцлага, нутгийн удирдлагуудтай хийсэн олон талт уулзалт, хэлэлцүүлгээс дүгнэхэд Хатанбулаг сум нь улсын эдийн засгийн хөгжилд гол хувь нэмэр оруулдаг, чухал үүрэг гүйцэтгэдэг сум болохыг судалгааны багийнхан ойлгосон юм. Уул уурхайгаас олох орлогыг нэмэгдүүлэх нь суманд том дарамт болдогоос гадна, экспортын хэмжээг нэмэгдүүлэх замаар улсын эдийн засагт дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөт үүрэг төр засгаас өгдөг тухай сумын засаг дарга хуваалцсан.

Эдийн засгийг дэмжих энэхүү дарамт шахалт нь нутгийн ард иргэдийг амь зуух, амьжиргаагаа залгуулах боломжгүйд хүргэх хэмжээний үнэ



цэнээр солигдож байгаад гомдолтой байгаагаа илэрхийлж байлаа. Учир нь улсаас төлөвлөсөн хатуу хучилттай зам болон төмөр замын барилгын ажил эцэс төгсгөлгүй үргэлжилснээс болж малчдын худаг руу явах зам хаагдаж, ундны усаа авах, малаа услахад хүндрэл үүсдэг болжээ.

Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн өсөлтийн хурд удааширсан нь нүүрсний олборлолтыг улам нэмэгдүүлэх, экспортын хэмжээг өсгөх илүү их дарамт суманд ногдуулжээ. Цар тахлын дараах эдийн засгийг сэргээх стратеги хэрэгжүүлэх нэрийн доор засгийн газар хүний эрхийг хамгаалах үүргээ орхигдуулж байна хэмээн нутгийн төрийн бус байгууллага (ТББ)-ууд хардаж байгаа ажээ.

## Хүн, малын эрүүл мэндэд учирч буй бэрхшээл

Замын барилгын ажил эхэлснээс хойш ханиад болон бусад амьсгалын замын архаг өвчлөлд хэрэглэдэг эм, тарианы борлуулалтын хэмжээ өмнөх үеийнхээс нэмэгдсэн хэмээн суманд үйл ажиллагаа явуулдаг хоёр эмийн санч хэлж байлаа. Мөн малын ам, нүднээс үргэлж юм гарах болж эрүүл уушигтай мал үлдээгүй хэмээн малчид хэлсэн юм. Нутгийн ТББ-тай

хийсэн хэлэлцүүлгийн үед тэд орчин тойрны өвс ногоо замын тоосонд дарагдсанаас болж малд идэх өвс хангалтгүй болж, мал туранхай, эцэнхий, тэжээлийн дутагдалд орж малын эндэгдэл элбэгшсэн гэжээ. Гэсэн хэдий ч бусад сумдын адилаар мөн л орчинд дэгдсэн тоосноос болж хүн, малын эрүүл мэнд доройтсоныг нотлох нь хүндхэн даалгавар болсон юм. Хэвлэл мэдээллээр зарим нэг фото зураг, дүрс бичлэг цацагдсан ч шүүхэд баримт нотолгооны шаардлага хангаагүй шалтгаанаар тэдгээр иргэдийн туулж буй зовлон бэрхшээлийг арилгах, шударга ёсыг тогтоож чадаагүй хэвээр байна.

Харин эсрэг талд Мон Лаа хэмээх төмрийн хүдэр олборлодог компаний уурхайн дарга нутгийн иргэдийг чин үнэнчээр эрхээ хамгаалуулахын оронд шалтаг хайн мөнгө салгах зорилготой байдаг бөгөөд малчдыг “залхуу”, улсад татвар төлдөггүй, маллаж буй малын тоо толгой бүрт төрөөс татаас авч, халамжаар амь зуух сэтгэлгээтэй болсон хэмээн буруушааж байв.





Хатанбулаг сумын иргэд бүлгийн хэлэлцүүлгээр хүний эрх болон ХЭХ-ийн хуулийн тухай ярилцаж, санал бодлоо солилцож буй байдал

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХ

### Ачааны машины тээврээс орчны тоос нэмэгдсэн

Хатанбулаг сумын иргэдэд тулгарч буй асуудлуудаас хамгийн ноцтой нь уурхайгаас ашигт малтмал тээвэрлэж буй ачааны машинуудын дэгдээж буй тоос гэжээ. Өдөрт 160-200 ачааны машин тээвэр хийн сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг гэсэн тоо баримт байдаг тухай сумын засаг дарга хуваалцсан бөгөөд тэдгээр ачааны машин сумын гурван багийн нутаг дэвсгэрээр дайран 222 км зам туулдаг байна. Зориулалтын хатуу хучилттай тээврийн зам байхгүй тул тэдгээр ачааны машинууд шороон замаар тээвэр хийж, орчны тоосыг улам дэгдээдэг юм.

Замын барилгын ажил хийгдэж байгаа ч хэзээ дуусч, ашиглалтад хүлээлгэн өгөх он, сар, өдөр тодорхойгүй бөгөөд саяхнаас барилгын ажил тодорхойгүй шалтгаанаар түр зогсоод байгаа юм байна. Заримдаа нутгийн иргэд тээврийн ачааны машиныг зогсоох оролдлого хийдэг ч тээвэрт саад учруулан зогсоосон цаг тутамд хохирлоо нэхэмжилнэ гэсэн сүрдүүлэгт өртдөг гэжээ.

Судалгааны багийнхан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөөлөгчтэй уулзсан ба саяхан уг байгууллага сумын иргэдээс орчны тоосны талаар ирсэн гомдлын мөрөөр хяналт, шалгалт явуулж, “тээврийн машины жолооч нарт шинэ зам гаргалгүй, зам дагуу зорчих” тухай үүрэг өгч ажилласан гэсэн юм. Гэсэн хэдий ч тээврийн жолоочид шинэ зам гарган дураараа зорчсон хэвээр байгаа бөгөөд энэ мэт арга хэмжээ авах нь хөрсөнд буудаггүй, хэрэгждэггүй, хэрэгжсэн ч түр хугацааных байдаг ажээ. Мэргэжлийн хяналтын нэг байцаагч нутгийн иргэнийг хувийнхаа машинаар өөрөө бас тоос гаргасан хэмээн гүтгэсэн байна. Энэ мэтээр эдийн засгийн өсөлтөд хэт анхаарлаа хандуулснаас болж сумын иргэдийн гомдол, саналыг үл ойшоодогт малчид сэтгэл дундуур байгаагаа хуваалцсан юм.

### Асуудал дагуулсан БОНУ

Уул уурхайн болон тээврийн компаниуд БОНУ-г батлуулахаасаа өмнө иргэдийн хурлаар хэлэлцүүлэх ёстой байдаг ч амьдрал дээр хэлэлцүүлэг хийлгүйгээр хайгуул хийж, замын барилгын ажлыг эхлүүлдэг хэмээн багийн засаг дарга нар хэлж байлаа. Тэгэхээр хэлэлцүүлэг гэдэг нь бэлэг тэмдэг төдий зүйл болж, нутгийн иргэдийн оролцоог хангах үндсэн зорилгоо



## ИРГЭНИЙ БА УЛС ТӨРИЙН ЭРХ

### Учир дутагдал бүхий Хамтран ажиллах гэрээ



Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр сумын зарим иргэд зөрчигдсөн эрхийнхээ хариуд нөхөн олговор авах зорилгоор тээврийн компаниудтай Хамтран ажиллах гэрээ байгуулсан тухайгаа ярьж байлаа. Гэвч уг гэрээг байгуулах явц ил тод бус, ямар сонгон шалгаруулалтаар хэнтэй байгуулж буй нь шударга бус явагдсан гэж үзэж байгаа ажээ. Тухайлбал тээврийн компаниудын үйл ажиллагаанд шууд өртөж буй олон айл өрх байтал зөвхөн тодорхой цөөн тооны иргэдэд Хамтран ажиллах гэрээг байгуулах боломж олдсон байна.

Хамтран ажиллах уг гэрээний эхийг тээврийн компаниуд бэлдсэн тул иргэд гэрээний зүйл заалтад ямар нэг санал оруулах эрхгүй, хэт нэг талыг баримталсан гэрээ болсон гэлээ. Малчид санал нийлж буй эсэхээс үл хамааран гарын үсэг зурахаас өөр сонголтгүй байсан бөгөөд нөхөн олговрын хэмжээ зэрэг гэрээний нөхцөлүүдэд компаниуд шударга бус хандсан тохиолдлууд байсныг ярьж байлаа. Тухайлбал Гэрээний дагуу олгож буй нөхөн олговроо малчдад олгож буй цалин, хөлс хэлбэрээр олгож, нийгмийн даатгалын тайланд тайлагнаж байгаа нь малчид өөрсдийнх нь эрхийг зөрчиж буй тэдгээр компаниудаас бүрэн хамааралтай, компанийн ажилтны байр сууринд очсон гэсэн үг юм. Учир нь Монгол улсын холбогдох хуулийн дагуу малчид 15 жил мал малласан бол тэтгэвэрт гарж, тэтгэврийн мөнгө авах эрх үүсдэг ажээ. Гэтэл малчдад олгож буй нөхөн олговрыг цалин, хөлсний орлого болгон тайлагнах нь тэдний тэтгэвэрт гарах хугацааг төдий хэрээр сунгаж, хойшлуулаад зогсохгүй “малчин” гэдэг ангилалаас нь хасагдахад хүргэх юм.

Нөхөн төлбөр авахаар сонгогдсон өрх, сонгогдоогүй өрх болон иргэд, багийн засаг дарга нарын хоорондын харилцаа ширүүсч, үл ойлголцох явдлууд ихэссэн байна. Учир нь багийн засаг дарга нар Хамтран ажиллах гэрээнд хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргаж тэдгээр компаниудад хүргүүлсэнтэй холбоотой гэнэ. Мөн засаг дарга нарын хасахыг санал болгосон өрхийг тэдгээр компаниуд Хамтрах ажиллах гэрээний нэрсээс хассан байсан тул засаг дарга нарыг танил талаараа асуудалд хандсан гэж нөхөн төлбөр авч чадаагүй үлдсэн өрхийн иргэд хардаж байгаагаа илэрхийлсэн юм. Ярилцлага өгсөн хэдэн иргэн Хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан иргэн компанийн эсрэг эсэргүүцэл, тэмцэлд оролцохыг хориглосон заалт байсан тухай дурдсан. Иймд хамтран ажиллах гэрээг иргэдийн дуу хоолойг хорих гол механизм болж хувирсан хэмээн дүгнэж болохоор байна.

биелүүлж чаддаггүй гэжээ. Хэлэлцүүлэг хийсэн ч БОНУ-г батлуулахад иргэд жинхэнэ утгаараа “оролцож” чаддаггүйд сэтгэл дундуур байдаг ба учир нь иргэдийн ирц бүртгэсэн гарын үсэгтэй хуудсыг компаниуд БОНУ-г хэлэлцэж, баталсан гарын үсэг болгон ашигладагт оршино. ТББ-ууд уул уурхайн компаниуд үйл ажиллагаа эрхэлж дууссаны дараа газар нутгийг нөхөн сэргээлгүй үлдээдэг хэмээн буруутгаж байна. Тиймээс ийм олон тохиолдолд ТББ-ууд байгаль орчинд учруулсан хохирлыг үнэлэн компаниудад хариуцлага тооцох арга хэмжээг санаачлан, хэрэгжүүлдэг байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь БОНУ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах үүрэгтэй хэдий ч Байгаль орчны яамнаас батлагдсан БОНУ-ийг цуцлах, хүчингүйд тооцох эрх мэдэлгүй байдаг тухайгаа судалгааны багийнхантай хуваалцсан юм. Ийнхүү систем дэх үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хуваарилалтад олон цоорхой үүсч, түүнийг ашиглан уурхайн компаниуд хүний эрхийг зөрчин байж эрх ашгаа хамгаалдаг жишиг тогтжээ.





## Даланжаргалан сумын малчин айл

Мон Лаа компанийн төлөөлөгчтэй хийсэн ярилцлагын үеэр дээрх Хамтран ажиллах гэрээг зөвхөн иргэдтэй байгуулаад зогсохгүй мөн сумын захиргаатай байгуулсан тухай судалгааны багийнханд хэлж байлаа. Тухайлбал Мон Лаа компани Хатанбулаг сумын хөгжилд зориулан 100 сая төгрөг (28,000 ам.доллар) хандивласан бөгөөд уг хандивыг зарцуулах шийдвэрийг сумын болон багийн засаг дарга нар нэн тэргүүнд шийдэх асуудлын дарааллын дагуу шийддэг юм байна. Үүгээр ч зогсоогүй Мон Лаа компани нь суманд 285 сая төгрөг (82,000 ам.доллар) бүхий үүрэн телефон сүлжээний станц байгуулж өгсөн бөгөөд дахин өөр нэг сүлжээний станц байгуулахаар ажиллаж буйгаа ярьж байлаа.

Ийнхүү сумын хөгжил компанитай байгуулсан Хамтран ажиллах гэрээнээс тодорхой хэмжээнд хамааралтай байгаа нь тэдгээр компаниудын хүний эрхийг зөрчсөн тохиолдлуудын эсрэг сумын засаг дарга дуу хоолойгоо хүчтэй гаргах боломжгүй болж байгаа нь илт байна.

## Сумын шийдвэр гаргах эрх мэдэл хангалтгүй

During the FFM team's meeting with local Сумын болон багийн засаг дарга нарын эрх мэдэл нь шийдвэр гаргах түвшинд хангалтгүй байдаг тухай орон нутгийн ТББ уулзалтын үеэр хэлж байлаа. Үүнийг бүлгийн хэлэлцүүлгийн үеэр багийн засаг дарга нар ч өөрсдөө баталж, тухайлбал сумын засаг дарга эрх мэдлийнхээ хүрээнд тултал асуудлыг шийдвэрлэх гарц хайдаг хэдий ч аймаг болон яамны хэмжээнд очоод уг асуудал шийдвэрлэгдэхгүй гацдаг тухай хуваалцсан юм. Мөн сумын засаг дарга бие даан шийдвэр гаргахгүйгээр аймгийн хэмжээнд шийдэгдсэн асуудлыг л үг дуугүй дагаж мөрдөх хэрэгтэй болдог хэмээн сумын иргэд хэлж байлаа. Нэг жишээ дурдахад, сумын газар нутагт тээврийн машинуудыг шороон замаар зорчихыг хориглох шийдвэр гаргасан байсан ч бодит байдалд хэрэгжээгүй бөгөөд харин ч эдийн засгийн өсөлтөд сумын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх нэрийн дор аймгийн засаг дарга тээврийн компаниудтай нэг тал болж сумыг шахаанд оруулдаг хэмээн иргэд хардаж байна. Үр дүнд нь тээврийн машинуудыг шороон замаар зорчихыг сум зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүржээ.



Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогддог процесс нь өөрөө их эргэлзээтэй. Зарчмын хувьд сумын нутаг дэвсгэрт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эсэхээс урьтаж, холбогдох хүсэлт нь сумын засаг даргийн тамгийн газарт ирэх ёстой. Уг хүсэлтүүдийг суманд эхлээд хүлээж аваад, сонгон шалгаруулаад, зөвхөн сонгогдсон хүсэлтүүдийг л аймагруу дараагийн шатанд илгээх ёстой. Гэвч бодит байдалд сумын засаг даргийн зөвшөөрөлгүйгээр бөөн бөөн тусгай зөвшөөрлүүд шууд аймгийн засаг даргийн зөвшөөрөлтэйгээр олгогдсон байдаг байна. Иймээс энэ мэт далд аргаар асуудлууд шийдэгддэг байдал хэвийн үзэгдэл болсон тул багийн засаг дарга нар өөрсдийгөө ямар нэгэн эрх мэдэлгүй зөвхөн “иргэдийн дуу хоолойг дамжуулах төдий үүрэгтэй” хэмээн ярьсан юм.

## Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал

Across the three soums visited, the FFM team met Судалгааны багийнхан дээрх гурван сумаар айлчлахдаа уул уурхайн компаниуд болон бусад оролцогч талуудын үйл ажиллагааны нөлөөнд өртсөн иргэдийн гомдол, саналыг

дангаараа болон бусад иргэдтэй хамтран илэрхийлдэг хэд хэдэн өрхийн малчин болон сумын оршин суугч иргэдтэй уулзаж ярилцсан юм. Уул уурхайн компаниудын байгаль орчинд хор хөнөөлтэй үйл ажиллагааг эсэргүүцэж, иргэдийн зөрчигдсэн эрхийг хамгаалахаар тэдний дуу хоолой болж, тэмцэж буйгаараа тэдгээр хүмүүс хүний эрхийн хамгаалагч (ХЭХ)-ийн тодорхойлолтод тохирч байлаа. Ярилцсан нийт ХЭХ-ийн тэн хагас нь эмэгтэйчүүд байсан бөгөөд ХЭХ нарт тохиолддог гол асуудлууд нь дээрх гурван сумын хувьд ижил, хоорондоо адилхан байв.

## СУМАН ДАХЬ ХЭХ-ЫН АЖИЛ

Хүний эрхийн хамгаалагчдын явуулж буй ажил, авч буй арга хэмжээ нь өөр хоорондоо харилцан адилгүй бөгөөд зарим тохиолдолд урт удаан хугацаанд үргэлжилсэн байх ажээ. Тухайлбал, Улаанбадрах суманд амьдардаг хүний эрхийн хамгаалагч эмэгтэй (ХЭХЭ) уул уурхайн компанийн өрөмдлөгийн үйл ажиллагааг эсэргүүцэж, уурхайн хашааны гадаа зохион байгуулсан тайван жагсаалд оролцсоныхоо төлөө хууль, хяналтын байгууллагынхны хараанд өртсөн гэжээ. Улаанбадрахын өөр нэгэн ХЭХ цацраг идэвхт бодисын мал амьтан, ундны усанд нөлөөлж буй хор уршгийг эсэргүүцэж,





## Даланжаргалан сум дахь уурхайн хаягдлын

Бадрах Энержи компанийн үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрлийг нь цуцлах тухай 1500 хүний гарын үсгийг цуглуулсан өргөдлийг МУ-ын засгийн газрын тэргүүн болон УИХ-ын даргад хүргүүлсэн байна.

Улаанбадрах суманд амьдардаг өөр олон ХЭХ уг компанитай холбоо тогтоох гэж оролдсон ч амжилтгүй болдог байсан тул тэд уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн бусад иргэдтэй нийлэн Бадрах Энержи компанийн хашааны гадна эсэргүүцлийн жагсаал зохион байгуулж, “дуу хоолой нь хэзээ ч хүрэх газраа хүрдэггүй” байсан хэмээн сошиал болон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр өөрсдөдөө тулгараад буй асуудлаа ярьсан хэмээн нэгэн ХЭХЭ хэлж байлаа. Орон нутгийн ТББ-ууд суман дахь ХЭХ-ийн үйл ажиллагааг урагшлуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал, хоёр ч ТББ сумын иргэдийг уурхайн компаниудын эсрэг гомдол гаргахаар Улаанбаатар хотруу зорчих тээвэр, хоол, байрны зардлаар нь хангаж, тусалсан хэмээн Улаанбадрах сумын ХЭХЭ хэлж байлаа. Өнгөрсөн хугацаанд уг ТББ-ууд мөн л сумын иргэдийг үндэсний телевизтэй хамтран хэвлэлийн бага хурал хийхэд нь тусалж байжээ. Бас нэгэн ХЭХЭ орон нутгийн ТББ-аас дэмжлэг авч байснаа хуваалцсан юм. Харин Даланжаргалан сумын нэг иргэн ХЭХ-ийн тухай хуулийн талаар танилцуулга хийхээр хотоос ТББ ирж, иргэдэд таниулсанд талархаж буйгаа илэрхийлж байлаа.

Улаанбадрах сумын бас нэгэн иргэн 2015 онд “Эх орон, эв нэгдлийн төлөө” нэртэй ТББ байгуулж, ураны олборлолтын нөлөөллийг судлах маш өргөн хүрээтэй судалгаа хийсэн ба уг судалгаанд Дорноговь аймгийн 4 сумын 53,000 хүн, 900,000 мал, 160 км радиус доторх газар нутаг хамарсан байна. Хатанбулаг сумын байгаль орчин, экосистемийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоёр ТББ-тай судалгааны багийнхан уулзаж, ярилцсан. Харамсалтай нь тэдгээр ТББ-ын төлөөллүүдийг аймгийн болон дээд шатны удирдлагууд бусад иргэдтэй адил үл тоомсорлодог тул зорьсон зорилгодоо хүрэх үр дүн бага байдаг талаараа хуваалцсан юм.

## ХЭХ БОЛОН ХЭХЭ-Н НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлгийн үеэр ажиглагдсан маш нийтлэг дүр төрх бол тэдгээр ХЭХ нар өөрсдийгөө ХЭХ гэдгээ ухамсарлахгүй байгааг гурван сумын малчид, эмэгтэйчүүдээс харж байлаа. Энэ нь тэд ХЭХ-ийн талаар болон тэдний үүргийн талаар маш хязгаарлагдмал мэдлэгтэй байгаатай холбоотой юм. Улаанбадрах сумын ХЭХЭ, ХЭХ-ийг “зөвхөн өөрсдийнхөө болон улс төрчдийн эрхийг л хамгаалдаг” гэж боддог бөгөөд учир нь хүний эрх зөрчигдсэн тохиолдол гарахад тэдгээр ХЭХ нар хэзээ ч гарч ирдэггүй гэжээ. Хэдийгээр ийм буруу ойлголт хачирхалтай санагдаж болох



ч энэ нь бүс нутгийн нийтлэг нөхцөл байдлыг харуулж байгаа юм.

Хөдөө эсвэл алслагдсан бүсэд амьдардаг, ихэвчлэн байгаль орчин, нийгмийн асуудалд анхаарч ажилладаг ХЭХ тэдэнд тусламж, дэмжлэг, хамгаалалт өгөх ёстой байгууллага, механизмаас авах ёстой тусламж дэмжлэгээ хангалттай хэмжээнд авч чаддаггүй. Газарзүйн алслагдсан байршилд амьдардгаас болж ХЭХ тэдгээр институтээс тусламж, дэмжлэг авах нь хэтэрхий хол, боломжгүй мэт мэдрэмжийг төрүүлдэг ажээ<sup>2</sup>.

2021 онд батлагдсан Монгол улсын Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай (Хүний эрх хамгаалагчийн тухай хууль гэдэг нэрээр танигдсан) хуулийн талаар гурван сумын иргэд ямар ч мэдээлэлгүй байсан гэж дүгнэхэд болно. Ярилцлага өгсөн ихэнх хүмүүс уг хуулийн талаар өмнө нь огт сонсож байгаагүй гэсэн хариулт өгсөн. Улаанбадрах сумын хоёр ХЭХ уг хуулийг “нэр төдий”, хэрэгжихгүй хууль гэсэн байр суурьтай байсан бол харин сумын засаг даргийн тамгийн газрын төлөөлөгчид болон орон нутгийн ТББ-ууд уг хуулийн талаар илүү их мэдээлэл авахыг хүсч буйгаа илэрхийлж байлаа.

Ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлгийн үеэр мэдрэгдсэн, өнөөгийн нөхцөл байдлын тухай нэг зүйл бол өмнө нь тэмцэж байсан олон асуудал үр дүнд хүрч сайжраагүй, хэвээр байгаад ХЭХ-ын урам нь хугарч, бууж өгөх хандлагатай болсон байлаа. Ялангуяа Улаанбадрах сумынхан олон жил эсэргүүцэж, тэмцсэн ч ямар ч үр дүнгүй, тэдний гомдол, цөхрөл хэний ч чихэнд хүрэхгүй байгаад бүх итгэл, найдвараа алдсан гэдгээ хүлээн зөвшөөрч байсан юм. Энэ нь ХЭХ-ийг дэмжих механизмд итгэх итгэлгүй байгааг харуулж байгаа ч нөгөөтэйгүүр ХЭХ-ийн хуулийг жинхэнэ хөрсөн дээр нь хэрэгжүүлэх ямар их хэрэгцээ, шаардлага байгааг давхар илтгэж байна.

## ХЭХ-ЫН ЭСРЭГ ДАРАМТ, ШАХАЛТ

ХЭХ-ын эсрэг дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагааг нь хааж боогдуулах үзэгдэл ховор биш ажээ. ХЭХ болон ТББ-ын ажилчдын эсрэг ирэх дарамт, шахалт нь зөвхөн уул уурхайн компанийн зүгээс ирээд зогсохгүй мөн төрийн байгууллагуудаас ч ирдэг тухай ярилцлагад оролцогсод гэрчилж байлаа. Тухайлбал, Улаанбадрах сумын ХЭХЭ өрөмдлөгийн ажлыг зогсоохыг оролдсоных нь төлөө цагдаагийнхан баривчлахыг завдсан ч бусад тэмцэгч нар эмэгтэйг тойрон хамгаалж, баривчлуулалгүй авч үлдэж чадсан гэжээ. Орой болж, харанхуй болсон хойно л цагдаагийнхан уг газраас явсан бөгөөд ХЭХЭ-н хэлснээр тэд анх компанийн дуудлагын дагуу ирсэн байна. Тус суманд бас нэгэн ХЭХ уурхайн үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрлийг нь цуцлуулах хүсэлт гаргасных нь хариуд түүнийг уул уурхайн компани хэд хэдэн удаа шүүхэд өгч байжээ.

ТББ-ын ажилчид нь ажил, үүргээ гүйцэтгэснийхээ төлөө эрхээ зөрчүүлсэн тохиолдол цөөнгүй ажээ. Тухайлбал, Улаанбадрах сумын ТББ-ын тэргүүнийг нэгэн төрийн албан хаагчийн гаргасан гомдлын дагуу цагдаагийн байгууллагаас шалгаж, олон улсын байгууллагаас санхүүжилт авч байна хэмээн хардан байцаасан байна. Цагдаагийнхан уг ТББ-ын данс тооцоог шалгасан бөгөөд гар утсыг нь ч чагнасан байж магад хэмээн тэрээр хардаж байжээ. ХЭХ-ын туулдаг дарамт, шахалт тэдний эрүүл мэнд, сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж, цаашлаад үйл ажиллагаагаа зогсоох шийдвэр гаргах хүртэл итгэл найдвараа алдацгаажээ. Зарим нь эрүүл мэндээрээ хохирч, зарим нь сэтгэл санааны хямралд автаж буй нь арьсанд харшил туурах, үс унах зэрэг шинж тэмдгээр илэрдэг байна.



## МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС (МХЭҮК)-ЫН ҮҮРЭГ

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль 2000 онд батлагдсанаар уг байгууллагыг байгуулжээ. 2020 онд комиссын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, комиссын бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн баталсан байна. Дараа жил нь хүний эрхийн хамгаалагчдын тухай хууль батлагдсанаар Хүний эрхийн хамгаалагчдын хороо (ХЭХХ)-г байгуулах нэмэлт үүргийг МХЭҮК-д ногдуулжээ. Хорооны гол үүргүүдийн нэг нь ХЭХ-ын эрх зөрчигдсөн тохиолдлуудыг мөрдөн, шалгах юм.

Судалгааны багийн хийсэн ихэнх ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгээр МХЭҮК-ын үйл ажиллагаа, үүргийн талаар ямар ч мэдлэг, мэдээлэлгүй байгаагаа ХЭХ уламжилж байсан юм. Тэр бүү хэл комисстой ямар нэг байдлаар хамтарч ажиллаж байсан эсэх асуултад ийм комисс байдаг гэдгийг мэдээгүй гэдгээр хариулж байлаа. Улаанбадрах сумын ХЭХЭ-н хэлснээр уг комисс хэмээх бэлэг тэмдэг төдий байгууллага “зөвхөн цаасан дээр л оршдог байх” гэсэн юм. Сумын хоёр иргэн МХЭҮК-ын талаар урьд нь сонсож байсан ч уг байгууллага иргэдийн эрх зөрчигддөг гол асуудлуудыг мэдэж байгаа эсэхэд эргэлзэж буйгаа ярьж байлаа.

Судалгааны багийнхны ярилцлага хийсэн нэгэн ХЭХЭ хэлэхдээ МХЭҮК нь эрх нь зөрчигдсөн ард иргэдийн эрхийг хамгаалах ажил хийхэд хэд хэдэн хүчин зүйлс саад болдог гэж үздэг тухайгаа хуваалцсан юм. Нэгдүгээрт, МХЭҮК үйл ажиллагаа явуулахад хөрөнгө мөнгө хангалттай хүрэлцдэггүй гэжээ. Үүнтэй холбоотойгоор хэлэхэд МХЭҮК нь тухайн жилийн үйл ажиллагаандаа зарцуулах төсвөө УИХ-д өргөн барьж, батлуулснаар, улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэгийг онцлох нь зүйтэй 1. Иймд МХЭҮК нь өөр эх үүсвэрээс (гадны донорууд) санхүүжилт эрэлхийлбэл уг байгууллагын үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэх давуу тал үүсэх боломжтойг ХЭХЭ хэлж байлаа. Түүний хөндсөн хоёр дахь асуудал бол МХЭҮК нь өөрсдийн чиг үүргийг маш явцуу хүрээнд хайрцагладаг тухай байв. Учир нь МХЭҮК-ын нэг гишүүн өөрсдийнх нь үндсэн үйл ажиллагааных нь чиглэлд заагдаагүй гэдэг шалтгаанаар дарамт, шахалтад өртсөн ХЭХ-ын гомдолд зохих ёсны арга хэмжээ аваагүй тохиолдлыг дурьдсан юм. Тиймээс иргэдээс ирсэн гомдлыг шийдвэрлэх чадавх комиссд байгаа эсэхэд эргэлздэг тухайгаа тэрээр ярьж байлаа. Ялангуяа ХЭХ-ийн тухай хуулинд зааснаар ХЭҮК-ын үүрэг бол эрх нь зөрчигдсөн ХЭХ-ын гомдлын дагуу шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг явуулах ёстой байтал дээрх хариултыг өгч буй нь ийнхүү эргэлзэхэд хүргэхэд аргагүй билээ.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан олон талт уулзалтын үеэр судалгааны баг ХЭҮК-ын ХЭХ-ын асуудлыг хариуцсан комиссартай уулзаж, ХЭХ-ийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Комиссын үйл ажиллагааных нь төлөвлөгөөтэй танилцсан юм. Комиссарын хэлж буйгаар ХЭХ-дын хорооны гишүүдийн сонгуулийг одоогоор зохион байгуулж байгаа бөгөөд хорооны үйл ажиллагаа 2023 онд эхлэх хүлээлттэй байгаа гэсэн. Энэхүү уулзалт болсон 2022 оны 10 дугаар сарын байдлаар Хорооны 6 гишүүний 4 гишүүн сонгогдсон байсан бөгөөд үлдсэн хоёр гишүүнийг 2023 оны 3 дугаар сард багтаан иргэний нийгмийн төлөөллөөс сонгоно гэлээ.

Дээр дурдагдсан мөрдөн шалгах ажиллагаанаас гадна, ХЭХХороо нь иргэний нийгмийн байгууллагын амсаж буй хүний эрхийн зөрчлийн талаар илүү судлахаар орон нутгийн иргэд, үйлдвэрчний эвлэл болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулна гэсэн юм. Комиссар мөн хэлэхдээ ХЭХ-ын туулж буй дарамт, сүрдүүлгийн талаар тодорхой мэдээлэлтэй ба ХЭХХуулийг суртачлах хувь хуульчид зэрэг хувь хүмүүсийг сургах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа ч гарч болох үр дагавраас болгоомжилж буйгаа мөн илэрхийлсэн билээ.

ХЭХХорооны бас нэгэн гол зорилго бол ХЭХХуулийг суртачлахын тулд сургалт зохион байгуулахаас эхлээд кампанит ажил хүртэл өрнүүлэх явдал гэжээ. Аль ч ажилд хөрөнгө мөнгөний тусламж хэрэг болох байх хэмээн Комиссар дурдсан. Сургалтууд нь төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, цагдаа болон прокурорынхонд чиглэгдэх ба тэдэнд ХЭХ болон ХЭХХуулийн талаарх мэдлэгийг нь дээшлүүлэх зорилготой байх бол кампанит ажил нь хуулийн агуулга болон иргэд, төрийн бус байгууллага, ХЭХ өөрсдөө хуулийг хэрхэн хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх болно гэжээ. Гурван сумаас хийсэн сурвалжлагаас харахад иргэдийн хуулийн талаарх мэдлэг маш хомс (ХЭҮК-ын үүрэг) байсан нь илт байсан. Мөн ийм үйл ажиллагааг хамгийн өргөн хүрээнд зохион байгуулах нэн шаардлагатай байгааг харуулж байна.

ХЭҮК нь уул уурхайн компаниудтай шууд хамтран ажилладаггүй ч Комиссын өмгөөллийн ажиллагааны зорилго нь уул уурхайн компаниуд хүний эрхийг зөрчсөн бол уг асуудлыг шийдвэрлэх ажлыг гүйцэтгэдэг хэмээн Комиссар нэмж хэлсэн юм.





Уурхайгаас ашигт малтмал тээвэрлэж буй замын дэргэд цугларсан хог





Даланжаргалан суманд ашигт малтмал тээвэрлэж буй байдал

# Дүгнэлт

Гурван суманд хийсэн судалгааны үр дүнд эрэн сурвалжлах багийн цуглуулсан мэдээ, баримтууд хүний эрх ноцтой зөрчигдсөн тохиолдлуудыг илрүүллээ. Уул уурхайн үйл ажиллагаа нь нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд аюул учруулаад зогсохгүй, цэвэр, эрүүл, аюулгүй, баталгаатай орчинд амьдрах эрхийг нь давхар зөрчиж байна. Тэдгээр уурхайн компаниуд хууль эрх зүйн цоорхой, тодорхой бус заалтуудыг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн овжин ашиглаж чадаж байгаа ч энэ үйлдэл нь ойр орчинд нь амьдарч буй иргэдэд сөрөг үр дагаврыг авчирч байна. Учруулсан хор хөнөөлөө арилгах зорилгоор уул уурхайн компаниуд нутгийн иргэдтэй хамтран ажиллах гэрээ байгуулдаг ч талуудын оролцоог тэгш хангаагүй, ил тод биш, шударга бус явагдаж байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих нэрийн дор засгийн газраас иргэдийнхээ эрүүл мэнд, сайн сайханд богино болон урт хугацаанд сөрөг үр дагавартай нөлөөллийг харгалзалгүй ашиг олох шийдвэрийг ахин дахин гаргасаар байна. Тусгай хамгаалалттай газар нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл давхардуулан олгож байгаа нь үүний тод жишээ юм. Төрийн байгууллагуудын шат шатны үүрэг, хариуцлагын хуваарилалт тодорхойгүй байдаг нь шийдвэр гаргах үйл явцыг ил тод бус, хариуцлагагүй явагдахад хүргэж, үүнээс болж иргэд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахад хүндрэл үүсч байна.

Заналхийлэх, айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх тактик ашиглан иргэдийн дуу хоолойг дарах, хүний эрхийн хамгаалагчдыг дуугүй болгох гэсэн оролдлого удаа дараа давтагдаж буйг судалгаанд оролцогсад илчилж байна. Энэ үйлдэл нь тэдний үндсэн эрх чөлөөнд халдаад зогсохгүй мөн улс орны ардчилал, иргэний нийгмийг санаатайгаар сүйтгэх вий гэсэн айдаст хөтлөх аюултай. Монгол улс хөршүүдийнхээ дунд хүний эрх, ардчиллын итгэл найдварын гэрэлт цамхаг болж байдаг тул дээрх айдас түгэх нь бүс нутгийн хүний эрхийн нөхцөл байдлыг бүхэлд нь хэдэн арван жилээр ухраахад хүргэж болох юм.

Хамгийн чухал нь энэ бүх асуудлуудын голд малчид өртөж байна. Засгийн газар энэ асуудлыг үл тоомсорлож, шийдвэрлэх арга хэмжээ авахгүй байгаа нь өн олон жил малчдын өөрсдийгөө малчин гэж тодорхойлж ирсэн бахархал, зорилго, хүндэтгэлийг салхинд хийсгэж буйтай агаар нэг. Яаралтай арга хэмжээ авахгүй бол малчдын амьдрал, ахуй аажим аажмаар устаж, таван хошуу малын бэлчээр дагаж амьдардаг нүүдэлчдийн өвөрмөц хэв маяг устаж үгүй болох эрсдэлд ойрхон байна.





**Хатанбулаг суманд үйл ажиллагаа явуулдаг Мон Лаа компанийн ил уурхай**

# ЗӨВЛӨМЖ

## Засгийн газарт өгөх зөвлөмж

- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг бүх хүнд баталгаажуулсан Монгол улсын Үндсэн Хуулийн зорилгыг дээдлэн, улс орны түүх, соёлыг 'өвлүүлэх, эрхэмлэх'-ийн ач холбогдлыг онцгойлон анхаарах;
- Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан өөрчлөлтийн 6.2 дугаар зүйлд заасан иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд байгалийн баялаг ашигласны үр шимийн ихэнхийг иргэд хүртэх үзэл баримтлалын дагуу ажиллах;
- Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 38, 29, 40 дүгээр зүйлийн дагуу уул уурхайн компаниуд байгаль орчныг хамгаалах үүргээ, төрийн захиргааны холбогдох төв болон орон нутгийн байгууллагууд байгаль орчныг хамгаалах, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх уурхайн компаний үйл ажиллагааг хянан гүйцэтгүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
- 2012 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18.4-р зүйлд заасан “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” гэсний дагуу нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд нөлөөлөх шийдвэрт иргэдийг тогтмол оролцуулах;
- Парисын зарчмын В.2 дахь хэсэгт нийцүүлэн МХЭҮК-т тогтвортой санхүүжилт олгож, уул уурхайн компаниудын хүний эрхийг зөрчсөн хэргийг цаг тухайд нь ил тод байдлаар хянан шалгаж, идэвхтэй хамтран ажиллах харилцааг хөгжүүлэх;
- 1994 онд батлагдсан Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутагт ашигт малтмалын ашиглалт, хайгуулын зөвшөөрөл олгохгүй байх;
- Ашигт малтмалын хайгуул хийх, олборлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, тусгай



зөвшөөрлийн хугацааг сунгахдаа нутгийн ард иргэдийн эрүүл, аюулгүй, баталгаатай орчинд амьдрах эрхийг хүндэтгэх, хамгаалах талаар тодорхой удирдамжаар хангаж, тавигдах шаардлагыг илүү нарийвчилж, шалгуурыг өндөрсгөх;

- Уул уурхайн үйл ажиллагаа нь нутгийн малчин иргэдийн амьдрал, амьжиргаанд шууд нөлөөлж байгааг хуулийн дагуу нотлоход тавигдах шалгуур, шаардлагын талаар хуулийн тодорхой удирдамжаар хангах;
- ХЭХ-ийн хуулийн 6, 9 дүгээр зүйлд заасны дагуу ХЭХ өөрийн болон хамт олныхоо эрхийг хамгаалах ажил зохион байгуулах эрхийг нь хүндэтгэн, аюулгүй орчинд үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангах.

## Аймгийн удирдагуудад өгөх зөвлөмж

- Уул уурхай малчдын амьдрал, амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар тэдний санаа бодлыг сонсохын тулд малчидтай тогтмол уулзаж хамтран ажиллах;
- Сум, багийн засаг дарга нарын орон нутгийн иргэдийн эрх зөрчигдсөн тухай тохиолдлыг бүртгэх, баримтжуулах, мэдээлэх ажлыг дэмжих;
- Холбогдох хууль, журмын биелэлтийг хангуулахын тулд аймгийн Мал эмнэлгийн газар, Байгаль орчны яам зэрэг бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;
- Орон нутгийн ТББ-үүдтэй хамтран орон нутгийн иргэдийн чадавхыг бэхжүүлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, бодлого боловсруулах үйл явцад оролцох оролцоог сайжруулах.

## Уул уурхайн компаниудад өгөх зөвлөмж

- Бизнес, хүний эрхийн талаарх НҮБ-ын зарчим болон уул уурхай, хүний эрх, байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг

бүрэн мөрдөж хэрэгжүүлэх;

- Үйл ажиллагаагаа дууссаны дараа газрыг нөхөн сэргээх, хамгаалах болон 1988 онд батлагдсан Монгол улсын Хөрсний тухай хуулийн 41-д заасны дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд үзүүлэх урт хугацааны нөлөөллийг хамгийн бага байлгах нөхцөлийг хангах;
- Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу сум, багийн засаг дарга болон нутгийн иргэдтэй тогтмол, цаг тухайд нь, ил тод харилцаа холбоо тогтоох замаар хариуцлага тооцох системийг сайжруулах;
- Уул уурхайн нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн олговор олгох шударга, ил тод тогтолцоог бий болгох;
- Засгийн газарт төлөх бүх татварыг цаг тухайд нь, бүрэн төлж барагдуулах.

## Хүний эрхийн хамгаалагчид өгөх зөвлөмж

- ХЭХ-ийн тухай хууль болон уг хуулийн дэмжих механизмтай танилцах ажлыг эрчимжүүлэх;
- Засгийн газар болон уул уурхайн компаниудын хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр орон нутгийн ТББ, иргэний нийгмийн байгууллага болон МХЭҮК-той хамтран ажиллаж, тэднийг байр суурийг бататгах, саналыг өргөжүүлэх;
- Өөрт тулгарч буй хүний эрхийн зөрчлийг өөрт буй хамгийн сайн боломжоор баримтжуулан, МХЭҮК-ын ХЭХ-ийн Хороонд мэдээлэх.

## Хүний эрхийн үндэсний комисст өгөх зөвлөмж

- ХЭХ-ийн Хорооны үйл ажиллагааны журмыг нэн тэргүүнд боловсруулах тэр дундаа эрсдэлийн үнэлгээ хийх журмыг яаралтай баталж, аль болох ойрын хугацаанд мөрдөж эхлэх,

- Улсын хэмжээнд ялангуяа ХЭХ, засгийн газар, төрийн албан хаагчид болон бусад оролцогч талуудын дунд ХЭХ-ийн тухай хуулийг суртачлах, таниулах, түгээхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх;
- Иргэдийг эвлэлдэн нэгдэж, арга хэмжээ авахад чадавхжуулах сургалт тогтмол зохион байгуулах замаар иргэдэд өөрсдийнх нь эрх, эрх мэдлийн талаар мэдлэг олгох;
- Аймгийн хэмжээнд болон өөрийн вэб сайтаар дамжуулан МХЭҮК-ын үйл ажиллагааны тухай мэдээллийг ХЭХ нарт хүргэх, хүртээмжийг сайжруулах;
- Уул уурхайн үйл ажиллагаа иргэд, малчдын амьжиргаа, эрүүл мэндэд нь хэрхэн нөлөөлж байгаа талаар хууль ёсоор хүлээн зөвшөөрсөн нотлох баримт цуглуулахад нь дэмжлэг үзүүлэх;
- МХЭҮК болон түүний үйл ажиллагааны тогтвортой байдал, түүний дотор хараат бус байдлыг баталгаажуулах гол түлхүүр болох санхүүжилтийн тогтвортой байдлыг Парисын зарчмын В.2-р хэсэг болон Хүний эрхийн институтын дэлхийн эвсэл (GANHRI)-ийн Магадлан итгэмжлэлийн дэд хорооны хаалттай санхүүжилтийн талаарх G.O.1.10 заалтыг хангах.

## Хэвлэл мэдээллийнхэнд өгөх зөвлөмж

- Хэвлэл мэдээллийн өөр өөр суваг ашиглан ард иргэдийн тэмцлийн дуу хоолойг тогтмол баримтжуулах, бэхжүүлэх;
- Засгийн газар болон уул уурхайн компаниудын үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг эрчимжүүлэх;
- Уул уурхайн ач холбогдлыг чухалчилсан үзлийн эсрэг ТББ-үүд болон иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж, тэдний кампанит ажил, өмгөөллийн үйл ажиллагааг нь онцлон дэмжих.



This publication was made possible by the generous support of Brot für die Welt, the European Union and the European Instrument for Democracy and Human Rights (EIDHR).

The contents of this publication are the sole responsibility of FORUM-ASIA and can in no way be taken to reflect the views of Brot für die Welt, the European Union and the European Instrument for Democracy and Human Rights (EIDHR).

**Brot**  
für die Welt



 PROTECT DEFENDERS.EU



